



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 30 өдөр


Дугаар 8/199

Улаанбаатар хот

Г “Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төв шалгаруулах болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ын 2.4.2.1, 2.4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвөөс томуу, томуу төст өвчний тусlamж, үйлчилгээний менежментийг эрс сайжруулж өөрийн харьяаллын нутаг дэвсгэрт амьдарч байгаа иргэдийн өвчлөлийг бууруулсан “Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийг шалгаруулж, дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, болзолт уралдааны удирдамжийг хоёрдугаар, дүгнэх зааврыг гуравдугаар, шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Болзолт уралдааныг зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газрын дарга, ажлын хэсгийн ахлагч /Я.Буянжаргал/-д үүрэг болгосугай.
3. Болзолт уралдааны санхүүжилтийг төсвийн болон олон улсын байгууллагын хандив тусlamжийн санхүүжилтээс шийдвэрлэхийг Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга /Д.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д үүрэг болгосугай.



Эрүүл мэндийн сайдын
2020 оны 10. сарын 30 өдрийн тушаалын
нэгдүгээр хавсралт 499

“Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төв шалгаруулж дүгнэх
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

Я.Буянжаргал, Эмнэлгийн тусlamжийн газрын
дарга

Ажлын хэсгийн нарийн бичиг

Н.Тунгалаг, Эмнэлгийн тусlamжийн газрын
Эмнэлгийн анхан шатны тусlamж,
үйлчилгээний бодлогын хэрэгжилт хариуцсан
мэргэжилтэн,

Ажлын хэсгийн гишүүд:

С.Энхжин, Хяналт, шинжилгээ дотоод аудитын
газрын Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний
хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн

Г.Оюунцэцэг, Эмнэлгийн тусlamжийн газрын
Эмнэлгийн тусlamжийн чанар аюулгүй
байдлын хэлтсийн Эрүүл мэндийн
байгууллагын магадлан итгэмжлэл хариуцсан
мэргэжилтэн

Ө.Энхмаа, Эмнэлгийн тусlamжийн газрын
Хүүхэд, нярайд үзүүлэх тусlamж, үйлчилгээний
асуудал хариуцсан мэргэжилтэн

Ц.Хандармаа, Нийгмийн эрүүл мэндийн газрын
Халдварт бус өвчин, осол гэмтлийн асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн

Д.Мягмарцэрэн, Ерөнхий мэргэжлийн салбар
зөвлөлийн дарга, ерөнхий мэргэжилтэн,
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их
сургуулийн Өрхийн анагаах ухааны тэнхимийн
эрхлэгч

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 10 сарын 30 өдрийн тушаалтын
хоёрдугаар хавсралт 499

“Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төв шалгаруулах
болзолт уралдааны удирдамж

Үндэслэл.

Тархвар зүйн 38 дугаар долоо хоногийн мэдээгээр улсын хэмжээнд томуу, томуу төст өвчин амбулаторийн үзлэгийн 4.1 хувь, 10,000 хүн амд 21.7 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх 7 хоногоос 0.9 хувь, 10,000 хүн амд 3.6 тохиолдол, сүүлийн 3 жилийн дунджаас 0.4 хувь, 10,000 хүн амд 3 жилийн дундаж үзүүлэлтээс 2.8 тохиолдлоор тус тус их байна.

Нийт эмнэлэгт хэвтэгсдийн дотор амьсгалын замын цочмог хүнд халдвартай эмчлүүлэгсэд 5.2 хувийг эзэлж, өмнөх 7 хоногоос 0.1 хувиар их, сүүлийн 3 жилийн дунджаас 2.5 хувиар бага, эмнэлэгт хэвтэгсдийн тоо батлагдсан орны тооноос хэтрээгүй хэвийн ажиллаж байна.

Томуу, томуу төст өвчнөөр өвчлөгсдийн дотор 89.8 хувийг 15, үүнээс 66.5 хувь нь 4 хүртэлх насыханд бүртгэгдэж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 5-24 хүртэлх насыханд 2.0 хувиар нэмэгдсэн байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдвартай 63.7 хувь нь 4 хүртэлх, үүний 29.5 хувь нь 1 хүртэлх насыханд бүртгэгдэж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 1-9 хүртэлх насыханд 5.1 хувиар нэмэгдсэн байна. Амьсгалын замын цочмог хүнд халдвартай шалтгаантай нас барагт бүртгэгдээгүй байна.

Томуу, томуу төст өвчний шалтгаантай түргэн тусламжийн дуудлага улсын хэмжээнд 5.8 хувь, Улаанбаатар хотод 30.2 хувь, аймгуудад 7.4 хувь -ийг эзэлж байна.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Вирус судлалын лабораторид нийт 23 сорьцыг шинжлэхэд томуугийн вирус илрээгүй, 6 (26.1 хувь)-д нь амьсгалын замын бусад вирус эерэг тодорхойлогдсон. COVID-19 халдвартай тархалттай бус нутгаас ирсэн 3,151 хүнээс амьсгалын замын сорьц цуглуулж, SARS-CoV-2 илрүүлэх шинжилгээ хийхэд 1 сорьцонд вирус эерэг тодорхойлогдсон.

2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар коронавируст (COVID-19) халдвартай зөөвөрлөгдөн ирсэн 313 тохиолдол шинжилгээгээр батлагдсан.

2020-2021 оны хүйтэн сэргүүний улиралд томуу, томуу төст өвчин, коронавирусийн (COVID-19) халдвартай давхцаж гарах эрсдэл маш өндөр байна. Иймд томуу, томуу

Зорилго: Өрхийн эрүүл мэндийн төвийн Томуу, томуу төст өвчний сэргийлэлт, эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээний менежментийг эрс өөрчлөн, хариу арга хэмжээний цогц нэгдмэл үйл ажиллагаа бий болгосон “Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төвийг шалгаруулж, урамшуулах.

Хамрах хүрээ: Нийслэл, аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй өрхийн эрүүл мэндийн төвүүд

Хугацаа: 2020 оны 11 дугаар сарын 02-ны өдрөөс 2021 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл.

Шалгаруулах байр, шагналын хэмжээ

Шалгаруулах байр	Шалгаруулах тоо	Шагналын хэмжээ
Нэгдүгээр байр	5	Автомашин
Хоёрдугаар байр	3	Иж бүрэн мобайл тоног төхөөрөмж
Тусгай байр	2	Багийн эмчийн цомог

Хүрэх үр дүн: Томуу, томуу төст өвчний эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ сайжирч хүндрэл, нас барагт эрс буурна.

Санхүүжилт: Төсвийн болон, олон улсын байгууллагын хандив тусlamж

Үр нөлөө:

Эрүүл мэндийн анхан шатны тусlamж, үйлчилгээний байгууллагын стандартын хэрэгжилт хангагдан, тусlamж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэн, чанар аюулгүй байдал сайжирна..

.....000.....

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 10. сарын 30. өдрийн тушаалтын
туравдугаар хавсралт №499

“Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төв шалгаруулж,
дүгнэх заавар

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь болзолт уралдааныг хэрэгжүүлсэн ажлын тайланг хүлээн авч болзол хангасан өрхийн эрүүл мэндийн төвийн материалыг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Эрүүл мэндийн яамны болзолт уралдааныг шалгаруулах ажлын хэсэгт ирүүлнэ.

1.2 Ажлын хэсэг үнэлгээний баг томилж, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн тайлантай танилцаж, үнэлгээ өгнө. Зарим шалгуур үзүүлэлтийн бодит байдлыг газар дээр нь шалгана.

1.3 Шалгаруулалтыг 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор багтаан зохион байгуулна

1.4 Уралдаанд өрхийн эрүүл мэндийн төвийг 1-2-р байр эзлүүлэн дүгнэнэ. Эхний гурван шалгуур үзүүлэлтийн дагуу авах онооны нийлбэр дээр Сэтгэл ханамжийн оноог тооцон нийт оноог гаргаж байр эзлүүлнэ.

Үүнд:

-Нэгдүгээр байранд: Нийт авах онооны 95 хувиас дээш оноо авсан 5 өрхийн эрүүл мэндийн төвийг,

-Хоёрдугаар байранд: Нийт авах онооны 90-94 хувь хүртэл оноо авсан 3 өрхийн эрүүл мэндийн төвийг,

-Тусгай байр: Менежментийн шинэ арга нэвтрүүлэн амжилттай ажилласан 2 өрхийн эрүүл мэндийн төвийг

1.5 Болзолт уралдаанд амжилттай оролцсон эрүүл мэндийн байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Хоёр: Ерөнхий мэдээлэл

2.1 Ерөнхий мэдээллийг хүснэгтийн дагуу бөглөнө. Үүнд:

2.1.1 Өрхийн эрүүл мэндийн төвийн оноосон нэрийг бичих,

2.1.2 Өрхийн эрүүл мэндийн төвийн байрлаж буй дүүрэг, хороог бичих,

2.1.3 Үйлчилгээний радиус үйлчлэх хүрээний хүн амын хамгийн алслагдсан өрх,

2.1.4 Үйлчлэх хүрээний хүн амын зорилтот бүлэг (Хүүхдийг насын бүлгээр гаргах: 1 хүртэлх насын, 5 хүртэлх насын, 5-9 насын, 10-14 насын, 15-19 насын хүүхэд,

Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд, жирэмсэн эхчүүд, 60-аас дээш настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд тус бүрээр)-ын тоог гаргах,

-хүн амыг эрүүл мэндийн 5 бүлгээр ангилж, 4-5-р бүлгийн хүн амын хаяг байршил, холбоо барих утсыг авсан байна.

-Хөдөлгөөнт хүн амын тоог гаргаж, зорилтот бүлгийн хүн амыг тодорхойлсон байна.

2.1.5 Нийт ажилтны тоог өгөгдсөн хүснэгтийн дагуу (албан тушаал, төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах албан сургалтаар эзэмшсэн мэргэшлээр гаргана) бөглөнө. Бусад гэдгийг мэргэжил, албан тушаалаар ялгаж гаргана.

Гурав. Шалгуур үзүүлэлтийг үнэлэх заавар

3.1 Удирдлага, зохион байгуулалт

3.1.1 Томуу, томуу төст өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар өөрийн байгууллагын чадавхийг үнэлсэн эсэх

- Өөрийн чадавхийг барилга, хүний нөөц (хангарт, сургагдсан байдал), эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн нөөцийн одоо байгаа нөхцөл байдлаа үнэлсэн бол 5 оноо, үнэлээгүй бол 0 оноо,

3.1.2 Үнэлгээний дагуу тулгамдаж байгаа асуудлаа тодорхойлж төлөвлөлт хийхдээ зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн нөөц, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг тооцож, дээрх нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг тооцон бэлэн байдлыг хангасан бол 5 оноо, төлөвлөгөөндөө дээрх чиглэлийн нөөцийг тооцоогүй эсвэл дутуу тооцсон бол 0 оноо.

3.1.3 Өөрийн байгууллагын ажилтнуудад Томуу, томуу төст өвчинөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (дархлаажуулалт, хамар, залгиурын халдвартгүйжүүлэлт, дархлаа дэмжих чиглэлээр зохион байгуулсан ажил) Дээрх арга хэмжээг бүрэн авсан бол 5 оноо, өөр чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулсан бол зохион байгуулсан ажил бүрт 1 оноо нэмэлтээр өгнө.

3.1.4 Томуу, томуу төст өвчинөөр эрүүл мэндийн төвд хандаж байгаа иргэд болон бусад өвчний улмаас төвд хандсан иргэдийн урсгал, зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээ (өрөөний байрлал, хаягжилт, ариутгал, халдвартгүйжүүлэлт, урсгал, ачаалал зохицуулалт гэх мэт): Авсан бол 5 оноо, аваагүй бол 0 оноо,

3.1.5 Хөнгөн, дунд, хүнд явцтай Томуу, томуу төст өвчтэй үйлчлүүлэгчийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан өвчлөлийн байдлыг тооцох. Тооцсон бол 5 оноо, тооцоогүй бол 0 оноо.

3.2 Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ

3.2.1 Томуу, томуу төст өвчлөлд өртөмхий бүлгийн судалгааг гаргасан эсэх

- хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа заавар, журмын дагуу өртөмхий бүлгийн судалгааг гаргасан бол 5 оноо, дутуу гаргасан, огт гаргаагүй бол 0 оноо

3.2.2 Өөрийн харьяа томуу, томуу төст өвчлөлд өртөмхий бүлгийн иргэдээс томуу, томуу төст өвчинеэс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдсан хувь - 95 хувиас дээш хувь бол 5 оноо, 80-94 хувь бол 3 оноо 70-79 хувь бол 1 оноо, 60 хувиас доош бол 0 оноо.

3.2.3 Томуу, томуу төст өвчинеэс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыаар хангаж, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байдал (Зорилтот бүлэг, тэдний онцлог хэрэгцээг харгалзах)

-Томуу, томуу төст өвчинеэс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сурталчилгааг 5-аас доошгүй төрлөөр боловсруулж мэдээллийн хэрэгсэл болон өөрийн байгууллагын сайт, ханын постер болон бусад хэлбэрээр тогтмол сурталчилсан бол 5 оноо, 2-4 бол 3 оноо, 2-оос доош төрөл бол 0 оноо. Вэб сайтед байрлуулсан материалын хандалтын тоо, мэдээллийн хэрэгслээр хэдэн удаа гаргасныг оноо өгөхдөө харгалзана.

3.2.4 Харьяаллын эрүүл мэндийн 4-5-р бүлгийн хүн ам, 5 хүртлэх насын хүүхдэд гэрийн эргэлтээр очиж зөвлөгөө өгсөн иргэдийн тоо

-Харьяаллын эрүүл мэндийн 4-5-р бүлгийн хүн амд гэрийн эргэлтээр очиж зөвлөгөө өгсөн иргэдийн хамруулалт 95 хувиас дээш бол 5 оноо, 80-94 хувь бол 4 оноо 70-79 хувь бол 3 оноо, 60-69 хувь бол 2 оноо, 59 хувиас доош бол 1 оноо. Гэрээр эргэлтээр очиж өгсөн зөвлөгөөг эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэн үйлчлүүлэгчээр, үйлчлүүлэгч чадамжгүй бол хууль ёсны асран хамгаалагчаар гарын үсэг зуруулсан байна.

3.3 Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ

3.3.1 Амьсгалын замын цочмог халдвартын шинж тэмдэгтэй өвчтөнийг эрэмбэлэн ангилах

-Томуу, томуу төст өвчний 2020 оны эмнэл зүйн зааврын дагуу бүрэн гүйцэд зөв үнэлсэн бол 5 оноо, эмнэлзүйн заавар баримтлаагүй бол 0 оноо

3.3.2 Томуу, томуу төст өвчинеэр хөнгөн, дунд явцтай өвчилсөн иргэдийг өдрөөр эмчилж эдгэрүүлсэн тоо /Үйлчлүүлэгчийг анхаарах: эрсдэлт бүлэг, эмзэг бүлгийн иргэдийг/

-Хөнгөн, дунд явцтай Томуу, томуу төст өвчинеэр өвчилсөн үйлчлүүлэгчийг өдрийн эмчилгээнд хамруулан 100 хувь эдгэрүүлсэн бол 5 оноо, 80-99 хувь бол 3 оноо, 80 хувиас доош бол 1 оноо.

3.3.3 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв болон ЭХЭМҮТ-д хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо

-Томуу, томуу төст өвчний хүндрэлээр эмнэлэгт хэвтсэн үйлчлүүлэгч байхгүй бол 5 оноо, /Нийгмийн байдлыг харгалзах/

-Тусlamж хайх мэдлэг дутмагийн (Мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдаагүй, дархлаажуулалтад хамруулаагүй, гэрээр эргэж зөвлөгөө өгөөгүй) улмаас томуу, томуу төст өвчинеэр өвчилж хүндрэн эмнэлэгт хэвтсэн бол хэвтэн эмчлүүлэгчийн тоогоор 5 оноо хасна.

3.3.4 Томуу, томуу төст өвчний дараа асаргаа, сувилгаа болон гэрийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийн тоо

-Томуу, томуу төст өвчнөөр өвдөж гэрийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж 100 хувь эдгэрсэн бол 5 оноо


-Томуу, томуу төст өвчнөөр өвдөж хэвтэн эмчлүүлээд эдгэрч гарсан үйлчлүүлэгчийн дахин хэвтэлтийн хувь /үйлчлүүлэгчийн нийгмийн байдлыг харгалзах/ 0 бол 5 оноо, 20 хүртэл 3 оноо, 20 хувиас дээш бол 5 оноо хасна.

3.4 Сэтгэл ханамжийн судалгааны дүн

3.4.1 Үйлчлүүлсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч эерэг, сөрөг сэтгэл ханамжийн хувиар оноог тооцно.

.....000.....

Эрүүл мэндийн сайдын
2020 оны 10. сарын 30 өдрийн тушаалын
дөрөвдүгээр хавсралт



“Иргэнд ээлтэй” өрхийн эрүүл мэндийн төв шалгаруулах шалгуур үзүүлэлт

Ерөнхий мэдээлэл

Өрхийн эрүүл мэндийн төвийн нэр	
Байршил /дүүрэг, хороо/	
Үйлчилгээний радиус /км/	
Үйлчлэх хүрээний хүн амын тоо	
<ul style="list-style-type: none"> - Суурин хүн ам - Хөдөлгөөнт хүн ам 	
Нийт ажилтны тоо	
<ul style="list-style-type: none"> - Эмч /мэргэшлээр/ - Сувилагч / мэргэшлээр/ - Нийгмийн эрүүл мэндийн ажилтан - Лаборант - Бусад 	

№	Шалгуур үзүүлэлт
НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:	
1.1	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар өөрийн байгууллагын чадавхийг үнэлсэн эсэх
1.2	<p>Томуу, томуу төст өвчний халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй эсэх</p> <p>Төлөвлөгөөнд дараахь зүйлийг тусгаж бэлэн байдлыг хангасан эсэх</p> <p>Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн нөөцийг тооцож, бэлэн байдлыг хангах;</p> <p>Зайлшгүй шаардлагатай санхүүгийн нөөцийг тооцсон эсэх</p>
1.3	Өөрийн байгууллагын ажилтнуудад Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1.4	Томуу, томуу төст өвчнөөр эрүүл мэндийн төвд хандаж байгаа иргэд болон бусад өвчний улмаас төвд хандсан иргэдийн урсгал, зохион байгуулалтын талаар авсан арга хэмжээ
1.5	Хөнгөн, дунд, хүнд явцтай Томуу, томуу төст өвчтэй үйлчлүүлэгчийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулан өвчлөлийн байдлыг тооцох.

ХОЁР. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	
2.1	Томуу, томуу төст өвчинд өртөмхий бүлгийн судалгааг гаргасан эсэх
2.2	Өөрийн харьяа Томуу, томуу төст өвчинд өртөмхий бүлгийн иргэдээс Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт хамрагдсан хувь
2.3	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалаар хангаж, соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байдал
2.4	Харьяаллын эрүүл мэндийн 4-5-р бүлгийн хүн амаас гэрийн эргэлтээр очиж зөвлөгөө өгсөн иргэдийн тоо
ГУРАВ: ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ	
3.1	Амьсгалын цочмог халдварын шинж тэмдэгтэй өвчтөнийг эрэмбэлэн ангилах
3.2	Томуу, томуу төст өвчнөөр хөнгөн, дунд явцтай өвчилсөн иргэдийг өдрөөр эмчилж эдгэрүүлсэн тоо
3.3	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв болон Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвтэн эмчлүүлсэн хүний тоо
3.4	Томуу, томуу төст өвчний өвчиллийн дараах асаргаа, сувилгаа хийсэн хүний тоо
ДӨРӨВ: СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮН	

.....000.....